



МОНГОЛ УЛС

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

1997 оны 8...
сарын 6-ны өдөр

Дугаар 8.

Улаанбаатар
хот

Нутгийн захиргааны байгуул-
лагуудад төрийн захиргааны
албаны 1997 оны мэргэшлийн
шалгалт авсан дүнгийн тухай

Нутгийн захиргааны байгууллагуудад төрийн захиргааны албанд шинээр орох иргэдээс төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалт авсан дүнгийн тухай Шалгалтын төв комиссын мэдээллийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Нутгийн захиргааны байгууллагуудад төрийн захиргааны албан тушаалд шинээр орох хүсэлтэй иргэдийн дунд зохион явуулсан төрийн захиргааны албаны 1997 оны мэргэшлийн шалгалтаар Улаанбаатар хот, 21 аймгийн төрийн захиргааны байгууллагад 641 ажлын байрны төлөө 781 иргэн өрсөлдөж, тэдгээрийн 379 нь буюу 48,5 хувь нь төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагуудад зохион явуулсан төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалт нь "Төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалт авах болзол, журам"-ын дагуу явагдсаныг тэмдэглэж Төрийн захиргааны албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Нутгийн захиргааны байгууллагуудаас Төрийн захиргааны албаны 1997 оны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэний нэрсийг төрийн захиргааны албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэн хавсралтын ёсоор баталж, зохих албан тушаалд томилуулахаар санал болгосугай.

2. Төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалтад цаашид иргэдийг өргөнөөр оролцуулж байх зорилгоор мэдээлэл, сурталчилгааны ажлыг өргөн зохион байгуулах арга хэмжээ авахыг Мэргэшлийн шалгалтын төв болон салбар комиссын дарга нарт даалгасугай.

3. Төрийн захиргааны удирдлагын хөгжлийн институтийн төрийн удирдлагын ангийг төгсөгчдийг төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалтад оруулахгүйгээр төрийн захиргааны албанд шинээр орох иргэдийн нөөцөд шууд бүртгэж байх боломжийг судалж, Төрийн захиргааны албаны зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Шалгалтын төв комисс /Х.Шаандар/-т даалгасугай.



Л. Лингов

Л.ЛИНГОВ

Төрийн захиргааны албаны
зөвлөлийн 1997 оны 8 дугаар
тогтоолын хавсралт

УХА 0115

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАНЫ МЭРГЭШЛИЙН 1997 ОНЫ ШАЛГАЛТАД
ТЭНЦЭЖ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛД АНХ ОРОХ ИРГЭНИЙ
НӨӨЦИЙН ЖАГСААЛТАД БҮРТГЭСЭН ИРГЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ**

| Д/Д | Албан байгууллага, албан тушаалын нэр | Шалгалтад тэнцсэн иргэний овог, нэр, мэргэжил | Мэргэшлийн шалгалтад авсан оноо |
|-----|---------------------------------------|---|---------------------------------|
| 1 | 2 | 3 | 4 |

Тав. Булган аймаг

| | | | |
|------|--|-------------------------------|----|
| 1. | Аймгийн Засаг даргын ТГ-т: -Нутгийн удирдлагын шийдвэрийн биелэлт хариуцсан ажилтан | 1. Хасбазарын ТАМЖИД | 42 |
| | -Мал аж ахуйн бодлого хариуцсан ажилтан | 1. Бавуугийн БАТБОЛД | 40 |
| | -Худалдаа, үйлдвэрийн бодлого хариуцсан ажилтан | 1. Нямдоржийн ЦЭНД-АЮУШ | 33 |
| | -Нийгмийн эрүүл мэндийн бодлого хариуцсан ажилтан | 1. Баасанжавын САНДАРМАА | 32 |
| 2. | Өлзийт тосгоны захирагчийн албанд татварын байцаагч | 1. Галданжамцын БАЯРАА | 34 |
| 3. | Сайхан сумын ЗД-ын ТГ- т татварын байцаагч | 1. Гончигсүрэнгийн ЭНХТУЯА | 33 |
| 4. | Бүрэгхангай сумын ЗД-ын ТГ-т татварын байцаагч | 1. Ёндонгийн БОЛДХУЯГ | 31 |
| 5. | Татварын хэлтэст хүн амын орлогын байцаагч | 1. Хишигнямын Больдирмаа | 31 |
| 6. | мөн хэлтэст хяналт шалгалтын байцаагч | 1. Рэнцэндоржийн БАТХИШИГ | 31 |
| Бүгд | | | 9 |